



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Монгол Ардын нам (МАН)-ын дарга
болон Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монгол Ардын нам (МАН)-ын дарга болон Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Г.Банзрагчийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Ардын намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Содбаатараас "... Монгол Ардын намын Ээлжит 31 дүгээр Их хурал 2025 оны 11 дүгээр сарын 15, 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, тус хурлаар намын даргыг шинээр сонгосон, мөн намын Үндсэн дүрэм, хөтөлбөрт Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн зохих нэмэлт, өөрчлөлтүүд оруулсаныг бүртгүүлэх тухай" өргөдлийг 255 хуудас баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ (эх хувь), 1 ширхэг флашны хамт 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан "Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам"-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба тухайн ажиллагааны явцад нэмэлтээр ирүүлсэн 55 хуудас баримтыг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэг.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Монгол Ардын нам (МАН)-ын даргаар Ням-Осорын Учралыг бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно" гэжээ.

Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Монгол Ардын нам (МАН)-ын Үндсэн дүрмийн (2021 оны) 17.4-т “Намын Их хурал намын бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:”, 17.4.3-т “Монгол Ардын Намын даргыг сонгох,...” гэж тус тус заасан байна.

Иймд Монгол Ардын нам (МАН)-ын Ээлжит 31 дүгээр Их хурлаар намын даргыг шинээр сонгосон үйл ажиллагаа нь хуулийн дээрх зохицуулалт болон тус намын дүрэмд нийцсэн байна.

1.1. Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан процессын талаар:

Монгол Ардын нам (МАН)-ын Үндсэн дүрмийн (цаашид “Үндсэн дүрмийн” гэх) 21.2-т “Намын Бага хурлын хуралдааныг ... намын Удирдах Зөвлөлийн санаачилгаар, ... зарлан хуралдуулж болно”, 28.1-д “Удирдах Зөвлөлийн хуралдааныг намын Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулна”, 28.5-д “Удирдах Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж буй асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж тогтоол гаргана”, 17.2-т “Намын ээлжит Их хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг хуралдах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө гаргана”, 17.3-т “Намын Их хурал хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг Бага хурал тогтооно” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтаас үзэхэд, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас Удирдах Зөвлөлийн хуралдааныг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зарлан хуралдуулсан, Удирдах Зөвлөлийн хуралдааны А/22 дугаар тогтоолоор Бага хурлын 8 дугаар хуралдааныг 2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зарлаж, хэлэлцэх асуудлыг тогтоожээ.

Улмаар МАН-ын Бага хурал 2025 оны 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд үргэлжилж, 2025 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 8 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолоор намын Ээлжит 31 дүгээр Их хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулахаар товлон зарлаж, 08 дугаар тогтоолоор намын Ээлжит 31 дүгээр Их хурлын бүрэлдэхүүнийг 2255 төлөөлөгчтэй байхаар тогтоож, “Монгол Ардын намын 31 дүгээр Их хурлын төлөөлөгч сонгох журам”-ыг баталсан нь Үндсэн дүрмийн 17.3 дахь хэсэгт нийцсэн гэж үзлээ.

Түүнчлэн, намын Удирдах зөвлөл, Бага хурал, Ээлжит 31 дүгээр Их хурлыг товлон зарлах болон хуралдааны товыг намын гишүүд, төлөөлөгчдөд журамд заасан хугацаанд, нийгмийн сүлжээн дэх тухайн намын цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн байна.

1.2. Намын Их хурлаас намын даргыг сонгож, баталсан талаар:

МАН-ын Ээлжит 31 дүгээр Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанд Их хурлын төлөөлөгчөөр албажсан 2247 төлөөлөгчөөс 2061 төлөөлөгч (91.7 хувь) оролцсон нь Үндсэн дүрмийн 18.1-д “Намын Их хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол Их хурлыг хүчинтэйд тооцно” гэж заасантай нийцсэн байна.

МАН-ын Үндсэн дүрмийн 1.5.3-т “Намын удирдах байгууллагыг сонгож байгуулах бөгөөд намын бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах

үйл ажиллагааг ил тод, нээлттэй, чөлөөт өрсөлдөөний зарчмаар явуулж, саналыг нууцаар хураах”, 1.5.4-т “Намын бүх шатны байгууллага асуудлыг чөлөөтэй хэлэлцэн цөөнхийн саналд хүндэтгэлтэй хандаж, олонх нь дэмжсэн шийдвэрийг нийтээрээ дагаж биелүүлэх ...”, 17.4-т “Намын Их хурал намын бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:” гээд 17.4.3-т “Монгол Ардын Намын даргыг сонгох, ...” гэж тус тус заасан.

Тухайн намын Ээлжит 31 дүгээр Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар МАН-ын даргын албан тушаалд Удирдах зөвлөлөөс Ням-Осорын Учралын нэрийг, танхимаас Баатаржавын Лхагважав нь өөрийн нэрийг тус тус нэр дэвшүүлсэн байх бөгөөд Тооллогын комиссын “Монгол Ардын намын даргыг сонгох, санал хураах, дүн гаргах журам”-ын дагуу санал хураалтыг явуулсан байна.

Намын Ээлжит 31 дүгээр Их хурлын Тооллогын комиссын “Намын даргад нэр дэвшүүлсэн нууц санал хураалтын дүнгийн тухай” 02 дугаар тогтоолоор Ням-Осорын Учрал 1974 санал буюу 94.95 хувь, Баатаржавын Лхагважав 105 санал буюу 5.05 хувийн санал тус тус авсныг баталж, улмаар 06 дугаар тогтоолоор Монгол Ардын нам (МАН)-ын даргаар Ням-Осорын Учралыг сонгож баталсан нь хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг, МАН-ын Үндсэн дүрмийн дээрх заалтуудад нийцсэн байх тул тус намын даргаар Ням-Осорын Учралыг бүртгэх нь зүйтэй.

Хоёр.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Монгол Ардын нам (МАН)-ын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэж шийдвэрлэлээ.

2.1.Намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан талаар:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гээд 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасан.

МАН-ын Ээлжит 31 дүгээр Их хурлыг зарлан хуралдуулсан процесс нь хууль болон тус намын дүрэмд нийцсэн талаар энэ тогтоолын 1.1 дэх хэсэгт дүгнэсэн болно.

Ийнхүү эрх бүхий этгээдээс зарласан МАН-ын Ээлжит 31 дүгээр Их хурал 2025 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр үргэлжилж, тус хуралдаанд Их хурлын төлөөлөгчөөр албажсан 2247 төлөөлөгчөөс 1840 төлөөлөгч (81.9 хувь) оролцож, тухайн өдрийн хуралдааны 10 дугаар тогтоолоор Монгол Ардын нам (МАН)-ын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан нь Үндсэн дүрмийн 18.1-д заасантай нийцсэн байна.

МАН-аас ирүүлсэн өргөдөлд намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан Тооллогын комиссын тогтоол ирүүлээгүйг тодруулахад, тус намаас ирүүлсэн 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 193 дугаар албан бичигт “Намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Их хурлаар нээлттэй хэлэлцэж, олонхоор шийдвэрлэсэн асуудлаар Тооллогын комиссын тогтоол гардаггүй, сонгогдсон тэргүүлэгч нарын тогтоолоор баталгааждаг болно” гэж тайлбарласныг хууль бус гэж үзэх үндэслэлгүй юм.

Мөн МАН-ын Үндсэн дүрэм нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан байх тул бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдсонгүй.

Үндсэн дүрмийн 33.3-т “Хяналтын Ерөнхий Хороог намын Их хурлаас 27 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэйгээр нэр дэвшүүлж ...” гэж тодорхой бус заасан нь хуульд нийцэхгүй байх боловч энэ талаар тус намын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 03 дугаар албан бичгээр “... Намын дүрэмд Хяналтын Ерөнхий Хорооны доод хязгаарыг 15 гишүүн байхаар оруулсан боловч Улсын дээд шүүхэд хүргүүлсэн намын дүрэмд техникийн алдаа гарч бичигдээгүй орхигдсон байх тул засаж хавсралтаар хүргүүлсэн болно ...” гэсэн тайлбар өгч, засвар оруулсан дүрмийг хавсралтаар ирүүлсэн тул хуулийн зөрчилгүй гэж үзлээ.

Иймд, Монгол Ардын нам (МАН)-ын даргаар Ням-Осорын Учралыг, мөн намын Үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг бүртгэх нь зүйтэй байна.

Монгол Ардын нам (МАН)-ын мөрийн хөтөлбөр хуульд нийцсэн болохыг дурдав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Монгол Ардын нам (МАН)-ын даргаар Ням-Осорын Учралыг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтыг баримтлан Монгол Ардын нам (МАН)-ын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ